



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Өмнөговь корпораци” ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2026/049/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Даланзадгад хот 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Г.Шижирболд Утас: 70533552 Цахим хаяг: shijirboldg@audit.gov.mn Аудитор: О.Чойдорж Утас: 70533552 Цахим хаяг: choidorjo@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	7
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	8
3.1 Албан шаардлага.....	8
3.2 Зөвлөмж	9
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	11
Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл.....	12
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539. Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.03.16 № 304
танай _____-ны № _____-т

“ӨМНӨГОВЬ КОРПОРАЦИ”
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Ч.ЭРДЭНЭДОРЖ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Өмнөговь корпораци ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар өөрийн орлогын төлөвлөгөөг тасалсан, авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, нөхөх олговор давхардуулан олгосон, шатахууны норм норматив хэтрүүлэн зарцуулсан зэрэг нийт 572,317.6 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 41 дүгээр зүйлийн 41.2.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 18 дугаар зүйлийн 18.1, 19.1, 20 дугаар зүйлийн 20.2.6, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.1.3, Авто тээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.1.4 дэх заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан 9,609,899.2 мянган төгрөгөөр ертөгтэй Оюутны хотхоны барилгыг бүртгэлд тусгасан байна.

4626050445

Р/2.Бичиг хэргэл 2026/03/16/СТА-н дүгнэлт/Төсөл.Босх

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй. Нутгийн дэм хөтөлбөрийн хүрээнд 153,006.0 мянган төгрөгийн урамшууллыг албан хаагчдад олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Эрх бүхий байгууллагын шийдвэрээр Монгол улсын хэмжээнд захиалагчийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллага болсон байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Д/Д	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,344,375,460.43	1,712,075,906.25
2	Дансны авлага	162,648,946.86	10,605,701.51
3	Бараа материал	246,272,407.50	264,543,310.10
4	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	56,646,123.36	56,646,123.36
5	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,809,942,938.15	2,043,871,041.22
6	Үндсэн хөрөнгө барилга	3,956,157,293.23	15,115,737,973.23
7	Биет бус хөрөнгө	1,842,793,062.22	1,827,940,562.14
8	Эргэлтийн хөрөнгийн дүн	5,798,950,355.45	16,943,678,535.37
9	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	7,608,893,293.60	18,987,549,576.59
10	Цалингийн өглөг	59,147.00	-
11	Татварын өр	112,294,819.12	64,437,003.25
12	Урьдчилж орсон орлого	2,837,791,776.04	2,882,670,292.21
13	Бусад богино хугацаат өр төлбөр	59,842,382.30	28,473,329.00
14	Богино хугацаат өр төлбөрийн дүн	3,009,988,124.46	2,975,580,624.46
15	Бусад урт хугацаат өглөг	818,837,460.35	12,120,411,233.35
16	Урт хугацаат өр төлбөрийн дүн	818,837,460.35	12,120,411,233.35
17	Өр төлбөрийн нийт дүн	3,828,825,584.81	15,095,991,857.81
18	Өмч: а) төрийн	106,230,485.61	106,230,485.61
19	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	2,655,179,985.00	2,655,179,985.00
20	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	1,018,657,238.18	1,130,147,248.17
21	Эздийн өмчийн дүн	3,780,067,708.79	3,891,557,718.78
22	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	7,608,893,293.60	18,987,549,576.59

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

(Төгрөгөөр)

Д/Д	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	2,241,660,295.06	2,262,457,410.15
2	Борлуулалтын өртөг	727,892,579.07	245,724,402.32
3	Нийт ашиг	1,513,767,715.99	2,016,733,007.83
4	Хүүний орлого	9,565,603.93	18,318,896.14
5	Бусад орлого	712,716,492.89	455,235,190.27
6	Борлуулалт, маркетингийн зардал	564,651,619.63	664,268,112.80
7	Ерөнхий ба удирдлагын зардал	1,846,580,667.90	1,413,402,296.42
8	Бусад зардал	361,371,039.46	270,420,000.00
9	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	6,544,829.24	-
10	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-552,663,947.35	123,877,788.88
11	Орлогын татварын зардал	-	12,387,778.89
12	Татвар дараах ашиг (алдагдал)	-552,663,947.35	111,490,009.99
13	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-552,663,947.35	111,490,009.99

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Мөнгөн орлогын дүн (+)	9,412,829,137.08	3,360,559,386.25
2	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,953,676,642.95	13,344,250.00
3	Бусад мөнгөн орлого	6,459,152,494.13	3,347,215,136.25
4	Мөнгөн зарлагын дүн (-)	9,667,158,624.63	2,939,787,967.43
5	Ажиллагчдад төлсөн	1,889,697,920.96	964,060,496.86
6	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	402,292,474.86	260,655,671.45
7	Бараа материалын худалдан авахад төлсөн	3,218,746,375.22	443,038,345.51
8	Ашиглалтын зардалд төлсөн	45,060,110.00	43,394,250.00
9	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	28,902,000.00	33,273,720.00
10	Хүүний төлбөрт төлсөн	-	-
11	Татварын байгууллагад төлсөн	408,952,261.88	340,731,566.61
12	Даатгалын төлбөрт төлсөн	6,636,525.00	-
13	Бусад мөнгөн зарлага	2,988,596,235.71	431,694,857.00
14	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-94,590,026.66	420,771,418.82
15	Мөнгөн зарлагын дүн (-)	58,684,799.90	53,070,973.00
16	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	58,684,799.90	53,070,973.00
17	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-58,684,799.90	-53,070,973.00
18	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-153,274,826.56	367,700,445.82
19	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,497,650,286.99	1,344,375,460.43
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,344,375,460.43	1,712,075,906.25

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
20 . . оны 12-р сарын 31 -ний үлдэгдэл	2,761,410,470.61	-	1,018,657,238.18	3,780,067,708.79
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө алдааны залруулга	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	-	-	111,490,009.99	111,490,009.99
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
20. . оны- р сарынний үлдэгдэл	2,761,410,470.61	-	1,130,147,248.17	3,891,557,718.78

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	2024 оны зорилтот түвшний		Зөрүү	Хувь
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Орлогын эх үүсвэр	4,509,942.0	3,360,559.4	1,149,382.6	74.5
Борлуулалтын орлого	3,085,000.0	2,479,415.2	605,584.8	80.4
Бусад орлого	-	881,144.1	(881,144.1)	
Нийт зардал	3,906,153.2	3,236,681.6	669,471.6	82.9
Урсгал зардал	2,746,153.2	2,028,200.2	717,952.9	73.9
төсөл хөтөлбөр нийт зардал	1,160,000.0	1,208,481.4	(48,481.4)	104.2
Татвар төлөхийн өмнөх ашиг	603,788.8	123,877.8	479,911.0	20.5
Орлогын татвар хураамж	60,378.9	12,387.8	47,991.1	20.5
Цэвэр ашиг	543,409.9	111,490.0	431,919.9	20.5

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 59,669.3 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 59,669.3 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

- Орлогын татварын зардал 7,134.3 мянган төгрөгийг орлогын дэлгэрэнгүй тайланд зардлаар, санхүү байдлын тайланд өглөгөөр тусгаагүй тайлагнасан
- Санхүүгийн байдлын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайланд үнэ шинэчлэн тогтоосон хөрөнгийн дүн 52,535.0 мянган төгрөгийг дахин үнэлгээний нэмэгдлээр тайлагнасан

Аудитаар нийт 658,548.1 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 572,317.6 мянган төгрөгийн 5 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 86,230.5 мянган төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

3.1 Албан шаардлага

1. Автомашинны шатахуун зарцуулалтыг тулган баталгаажуулахад Toyota Land Cruiser маркийн 00-65 ӨМӨ улсын дугаартай автомашинд 2,789.8 литр буюу 7,114.0 мянган төгрөг, Landcruise j76 маркийн 67-97 ӨМА улсын дугаартай автомашинд 841.8 буюу 2,988.3 мянган төгрөгийн шатахууныг норм хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"* Автотээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д *"автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ"* 6.1.4-т *"тээвэрлэлтийн үйл ажиллагаа, тээврийн хэрэгслийн техник ашиглалтын талаар нийтлэг мөрдөх дүрэм, журам, норм, нормативыг батлах, тэдгээрийн биелэлтийг хангуулах"* Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан *"Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"*-той тус тус нийцэхгүй байна.

2. Байгууллагын аварга ажилтан болон төрийн одон медалиар шагнагдсан албан хаагчдад 4,516.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т *"Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:"*, 15.1.3-т *"хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох"* гэж заасантай нийцэхгүй байна.

3. Тайлант хугацаанд албан томилолтын хоолны мөнгөтэй давхардуулан 1,284.1 мянган төгрөгийн хоолны хөнгөлөлт олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"* гэж заасантай нийцэхгүй байна.

4. Тайлант хугацаанд өөрийн орлогын төлөвлөгөөг 494,346.1 мянган төгрөгөөр тасалсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дугаар зүйлийн 41.2.1-т *"хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх"* гэж заасантай нийцэхгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5. Санхүүгийн тайланд бүртгэлтэй 62,069.2 мянган төгрөгийн өндөр насжилттай авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "*Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ*", 19 дүгээр зүйлийн 19.1-д "*Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно*", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдээдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*" гэж заасантай нийцэхгүй байна

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжтой холбоотой асуудал

Илрүүлэлт:1 Тус байгууллага нь үйл ажиллагаандаа дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д "*Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана*" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг боловсруулан батлуулж, түүний дагуу нягтлан бодох бүртгэлээ хөтлөн ажиллах

Илрүүлэлт:2 Аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-нд тус газрын бүтэц орон тоонд чиг үүрэгт хамааралгүй Оюутны хотхоны бүтцийг нэмж 10 орон тоотой байхаар тусгасан байна.

Энэ нь Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1-т "*Энэ хуулиар Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн чиг үүрэг, эдийн засгийн үндэс, нэгжийг өөрчлөх үндэслэл журмыг тодорхойлж, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх өөрийн болон төрийн удирдлагын тогтолцоо, үйл ажиллагааны зарчим, нутгийн өөрийн удирдлагын байгууллагын эрх хэмжээ, зохион байгуулалт, бүх шатны Засаг даргын бүрэн эрх, нутгийн удирдлагаас бусад байгууллагатай харилцах харилцааг зохицуулна*", 20 дугаар зүйлийн 20.3-д "*Нутгийн өөрөө удирдах байгууллага энэ хуулийн 20.1-д заасан чиг үүргээс гадна Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг баримтлан нутаг дэвсгэрийнхээ тодорхой асуудлыг бие даан шийдвэрлэж болно*", 35 дугаар зүйлийн 5.1.12-д "*орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Газрын бүтэц, орон тоог иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр батлуулж ажиллах

Илрүүлэлт:3 Аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-ний 1-5 дугаар хавсралтуудыг холбогдох шийдвэргүйгээр өөрчлөн засварласан байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1-т "Талууд харилцан тохиролцож хөдөлмөрийн гэрээнд өөрчлөлт оруулж болно.", "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-ний 6.1-д "Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт өөрчлөлт оруулж болно. Гэрээний нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэн зохих журмын дагуу баталгаажуулах бөгөөд энэхүү гэрээний салшгүй хэсэг болно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Засаг дарга гүйцэтгэх захиралтай байгуулах "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-ний нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэн зохих журмын дагуу баталгаажуулж ажиллах

Илрүүлэлт:4 Аймгийн Засаг даргын 2025 оны А/1546 дугаар захирамжаар тус газарт Улаанбаатар хот дахь Өмнөговь аймгийн оюутны хотхоны үйл ажиллагааг удирдах, холбогдох журмыг боловсруулж батлах, үр дүнтэй хүртээмжтэй байхаар зохион байгуулах нэмэлт чиг үүргийг хариуцуулсан байна.

Энэ нь Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1-т "Энэ хуулиар Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн чиг үүрэг, эдийн засгийн үндэс, нэгжийг өөрчлөх үндэслэл журмыг тодорхойлж, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх өөрийн болон төрийн удирдлагын тогтолцоо, үйл ажиллагааны зарчим, нутгийн өөрийн удирдлагын байгууллагын эрх хэмжээ, зохион байгуулалт, бүх шатны Засаг даргын бүрэн эрх, нутгийн удирдлагаас бусад байгууллагатай харилцах харилцааг зохицуулна", 20 дугаар зүйлийн 20.3-д "Нутгийн өөрөө удирдах байгууллага энэ хуулийн 20.1-д заасан чиг үүргээс гадна Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг баримтлан нутаг дэвсгэрийнхээ тодорхой асуудлыг бие даан шийдвэрлэж болно", 35 дугаар зүйлийн 5.1.12-д "орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Илрүүлэлт:5 Улсын бүртгэлийн гэрчилгээ болон санхүүгийн тайлангаар эздийн өмчийн дүн 86,230.5 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

Энэ нь Улсын бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т "Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн дараах мэдээлэл нээлттэй байна.", 12.2.3-т "хуулийн этгээдийн нэр, хаяг, регистрийн дугаар, төрөл, хэлбэр, үйл ажиллагааны чиглэл, улсын бүртгэлд бүртгэсэн огноо, үүсгэн байгуулагчийн нэр, тэдгээрийн тоо, хувьцаа эзэмшигчийн нэр, эцсийн эзэмшигч, эцсийн өмчлөгчийн нэр, итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээдийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хуулийн этгээд өөрчлөн байгуулагдсан эсэх, хэлбэр, оноосон нэр өөрчлөгдсөн, татан буугдсан талаарх мэдээлэл", Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны Дүрэм шинэчлэн батлах тухай 14/08 дугаар тогтоолоор баталсан "Өмнөговь корпораци" орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын дүрэм -ийн 5.5-д "Үйлдвэрийн газрын өөрийн хөрөнгө буюу дүрмийн санд өөрчлөлт оруулсан хөрөнгийн бүртгэлийн жагсаалтыг улсын бүртгэлийн материалд тухай бүр оруулж байна" гэж заасантай тус тус нийцээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөг)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орлогын татварын зардал 7,134.3 мянган төгрөгийг орлогын дэлгэрэнгүй тайланд зардлаар, санхүү байдлын тайланд өглөгөөр тусгаагүй тайлагнасан	1	7,134.3	1	7,134.3			1	7,134.3				
Санхүүгийн байдлын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайланд үнэ шинэчлэн тогтоосон хөрөнгийн дүн 52,535.0 мянган төгрөгийг дахин үнэлгээний нэмэгдлээр тайлагнасан	1	52,535.0			1	52,535.0	1	52,535.0				
Дүн	2	59,669.3	1	7,134.3	1	52,535.0	2	59,669.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Автомашинуы шатахуун зарцуулалтыг тулган баталгаажуулахад Toyota Land Cruiser маркийн 00-65 ӨМӨ улсын дугаартай автомашинд 2,789.8 литр буюу 7,114.0 мянган төгрөг, Landcruise j76 маркийн 67-97 ӨМА улсын дугаартай автомашинд 841.8 буюу 2,988.3 мянган төгрөгийн шатахууныг норм хэтрүүлэн зарцуулсан	1	10,102.3			1	10,102.3							
Байгууллагын аварга ажилтан болон төрийн одон медалиар шагнагдсан албан хаагчдад 4,516.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон	1	4,516.0			1	4,516.0							
Тайлант хугацаанд албан томилолтын хоолны мөнгөтэй давхардуулан 1,284.1 мянган төгрөгийн хоолны хөнгөлөлт олгосон	1	1,284.1			1	1,284.1							
Тайлант хугацаанд өөрийн орлогын төлөвлөгөөг 494,346.1 мянган төгрөгөөр тасалсан байна.	1	494,346.1			1	494,346.1							
Санхүүгийн тайланд бүртгэлтэй 62,069.2 мянган төгрөгийн өндөр насжилттай авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй	1	62,069.2			1	62,069.2							
Тус байгууллага нь үйл ажиллагаандаа дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.	1	-					1	-					
Аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-нд тус газрын бүтэц орон тоонд чиг үүрэгт хамааралгүй Оюутны хотхоны бүтцийг нэмж 10 орон тоотой байхаар тусгасан байна.	1	-					1	-					
Аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-ний 1-5 дугаар хавсралтуудыг холбогдох шийдвэргүйгээр өөрчлөн засварласан байна.	1	-					1	-					

Аймгийн Засаг даргын 2025 оны А/1546 дугаар захирамжаар тус газарт Улаанбаатар хот дахь Өмнөговь аймгийн оюутны хотхоны үйл ажиллагааг удирдах, холбогдох журмыг боловсруулж батлах, үр дүнтэй хүртээмжтэй байхаар зохион байгуулах нэмэлт чиг үүргийг хариуцуулсан	1	-					1	-				
Улсын бүртгэлийн гэрчилгээ болон санхүүгийн тайлангаар эздийн өмчийн дүн 86,230.5 мянган төгрөгөөр зөрүүтэй	1	86,230.5					1	86,230				
Дүн	10.0	658,548.2	-	-	5	572,317.7	5	86,230.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим системд байгууллагын нэрийг шинэчлээгүй, төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарыг 5,7,8,9,10,11,12 дугаар саруудад, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны тайланг тус тус мэдээлээгүй	1	-					1	-
Дүн	1	-					1	-